

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**“Галт дулаан” ХХК -ийн 2025 оны санхүүгийн тайлан, тодруулгад
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан.**

Аудитын код: ХӨА-2026/029/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн захирал: Д.Мягмарсүрэн
Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 01/294
танай _____-ны № _____-т

“ГАЛТ ДУЛААН” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.МӨНХ-ОЧИР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Галт дулаан” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

“Галт дулаан” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 85,667.4 мянган төгрөгийн тогооны барилга байгууламж, 162,650.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 765.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 246,276.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 204,096.1 мянган төгрөгийн, төсөв зарцуулалттай холбоотой 42,180.5 мянган төгрөгийн зөрчилд холбогдох шийдвэрийг гаргаж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Компанийн дүрэмд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй ба тэдгээрийн 3 гишүүн нь төрийн албан хаагч, 2 гишүүн нь

иргэний төлөөлөл байна. 2025 онд ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	82,697,398.10	8,282,414.88
1.1.2	Дансны авлага	36,212,484.03	183,163,023.67
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	77,992,144.29	108,978,686.74
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	0.00	0.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	196,902,026.41	300,424,125.29
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,820,995,668.77	1,993,828,869.26
1.2.2	Биет бус хөрөнгө	15,036,750.00	14,968,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,836,032,418.77	2,008,796,869.26
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,032,934,445.18	2,309,220,994.55
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	110,780,447.59	102,353,655.01
2.1.1.2	Цалингийн өглөг	(0.00)	(0.00)
2.1.1.3	Татварын өр	5,978,250.97	40,566,058.01
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.00	17,512,594.27
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	116,758,698.56	160,432,307.29
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	44,615,930.33	44,615,930.33
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.5		0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	44,615,930.33	44,615,930.33
2.2	Өр төлбөрийн нийт дүн	161,374,628.89	205,048,237.62
2.3	Эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.3.1	Өмч: - төрийн	894,273,469.00	894,273,469.00
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- Хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	416,402,033.53	416,402,033.53
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	374,089,396.00	711,237,100.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	186,794,917.76	186,794,917.76
2.3.10	Тайлант үеийн ашиг алдагдал	0.00	(104,534,763.36)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,871,559,816.29	2,104,172,756.93
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	2,032,934,445.18	2,309,220,994.55

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	697,181,070.68	792,675,201.49
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	598,376,360.79	564,681,692.22
3	Нийт ашиг (алдагдал)	98,804,709.89	227,993,509.27
4	Түрээсийн орлого	6,290,909.09	4,772,727.27
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	185,837,805.00	336,377,099.00
11	Санхүүгийн зардал	160,620.00	133,000.00
12	Бусад зардал	0.00	0.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(8,681,653.03)	(790,900.90)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(89,584,459.04)	(104,534,763.36)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(89,584,459.04)	(104,534,763.36)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(89,584,459.04)	(104,534,763.36)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	(89,584,459.04)	(104,534,763.36)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	800,891,203.60	753,744,862.63
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	763,411,912.79	740,663,945.63
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
	Бүцаан авсан албан татвар	13,621,954.81	0.00
	Татаас, санхүүжилтын орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	23,857,336.00	13,080,917.00
1.2	Мөнгөн зарлага (-)	850,242,834.58	830,713,845.85
	Ажиллагчдад төлсөн	314,603,576.00	336,306,285.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	77,339,929.14	77,920,441.49
	Бараа материал худалдан авахад төлсөн	64,567,540.00	67,449,303.16
	Ашиглалтын зардалд төлсөн	40,952,269.07	87,649,612.36
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	139,961,710.00	105,084,120.00

	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	99,049,014.30	61,811,902.46
	Даатгалын төлбөрт төлсөн	613,000.00	0.00
	Бусад мөнгөн зарлага	113,155,796.07	94,492,181.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(49,351,630.98)	(76,968,983.22)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,495,000.00)	0.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,495,000.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,495,000.00	0.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахал төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(61,846,630.98)	(76,968,983.22)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	144,544,029.08	82,697,398.10
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	82,697,398.10	8,282,414.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	894,273,469.00	416,402,033.53	14,968,000.00	258,378,088.74	1,584,021,591.27
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	894,273,469.00	0.00	0.00	0.00	894,273,469.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	21,254,393.66	21,254,393.66
2025 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	894,273,469.00	416,402,033.53	711,237,100.00	186,794,917.76	2,208,707,520.29

Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(104,534,763.36)	(104,534,763.36)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	337,147,704.00	0.00	337,147,704.00
2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	894,273,469.00	416,402,033.53	711,237,100.00	82,260,154.40	2,104,172,756.93

2.4 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Мянган төгрөгөөр

	Үзүүлэлт	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин	376,943.50	360,357.90	16,585.60	95.6
2	НДШ	48,198.60	45,066.80	3,131.80	93.5
3	Албан томилолт	1,600.00	-	1,600.00	-
4	Шуудан холбоо, хэвлэл захиалга	510.00	250.00	260.00	49.0
5	Бичиг хэрэг	1,110.70	893.30	217.40	80.4
6	Хөдөлмөр хамгаалал	25,897.50	4,315.50	21,582.00	16.7
7	Нүүрсний зардал	97,707.50	85,917.60	11,789.90	87.9
8	Түлээний зардал	2,100.00	-	2,100.00	-
9	Түлш шатахуун	65,647.00	46,830.50	18,816.50	71.3
10	Нүүрс тээвэр	65,632.00	62,658.80	2,973.20	95.5
11	Үндсэн хөрөнгийн элэгдэл	147,119.70	163,527.30	(16,407.60)	111.1
12	Цахилгааны зардал	39,680.10	56,312.90	(16,632.80)	141.9
13	Цэвэрлэгээний материал	1,508.00	1,146.30	361.70	76.0
14	Урсгал зардал	18,085.00	863.70	17,221.30	4.8
15	Сэлбэгийн зардал	11,072.50	15,862.40	(4,789.90)	143.3
16	Төлбөр хураамж	15,794.40	24,928.20	(9,133.80)	157.8
17	Тэтгэмж урамшуулал	27,219.00	28,811.70	(1,592.70)	105.8
18	Засвар үйлчилгээ	431.50	2,025.40	(1,593.90)	469.4
19	Бусад зардал	2,079.30	863.70	1,215.60	41.5
20	Туз зардал	7,063.30	1,350.00	5,713.30	19.1
21	Түрээсийн зардал	2,700.00	-	2,700.00	-
22	Тавилга эд хогшилын зардал	3,030.00	-	3,030.00	-
Зардал		965,018.00	901,982.70	63,035.30	93.5
Орлого		901,065.70	797,447.90	103,617.80	88.5
Ашиг ,алдагдал		(63,952.30)	(104,534.80)	40,582.50	(4.97)
Татаасын дараах ашиг ,алдагдал		(60,754.60)	(94,081.20)	33,326.60	154.9

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 246,276.6 мянган төгрөгийн 2 алдаа 6 зөрчил илэрснээс 431.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 43,961.3 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх 3 зөрчилд албан шаардлага, 175,421.6 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмжийг тус тус өгсөн.

Залруулсан алдаа:

- Татварын тайлангийн орлого, орлого үр дүнгийн тайлангийн орлого 26 461.9 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх"; 5.1.5-д "хэмжигдэхүйц байх"; 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 65 дугаар зүйл НББ-ын зарчим дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт зөрчигдөж байна.

3.1 Төлбөрийн акт

- Шатахууны тооцооллыг шалгахад сарын бүрийн эцэст шатахууны тооцоог бодсон 6 сард 147.5 литр 431.7 мянган төгрөгийн түлш илүү зарцуулснаар тооцсон байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", ЗТХС-ын 2019 оны 390 тушаалаал батлагдсан "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" , "Шатахуун зарцуулалтын сорил, туршилтын ажлыг гүйцэтгэхийн тулд автомашины техникийн байдлыг оношилж, шатахуун зарцуулалтад нөлөөлөх эвдрэл, гэмтэлгүй гэдгийг тогтоосон тохиолдолд сорил, туршилтын ажлыг хийж, бодит зарцуулалтыг тогтооно" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй ба “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- Тайлангийн хугацааны эцэст 30 959.0 мянган төгрөгийн авлага, 13 002.3 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй ба “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.
- Компанийн ТУЗ-өөс 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 60 754.7 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан. Тайлант онд орлогын төлөвлөгөөг 69 307 мянган төгрөгөөр тасалдуулан, цахилгааны зардал, төлбөр хураамж, сэлбэг хэрэгсэл, тэтгэмж урамшууллын зардлууд батлагдсан төлөвлөгөөнөөс хэтэрсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;” Засгийн газрын 2020 оны 217 тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур

үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” -ын 2.2-т “Төлөвлөгөөг боловсруулахдаа стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна” гэсэн заалтуудыг зөрчсөн ба “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй ба 3 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллогын комиссын тушаал, худалдан авах ажиллагааны тайлан, нэмэгдсэн хасагдсан хөрөнгийн шийдвэр зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлээгүй ба “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 133 216.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй 19 нэр төрлийн 20 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалт зөрчсөн ба “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдүүлэх

2. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй газар эзэмших эрхийн хэмжээ цахим системээс 228м.кв буюу 456.0 мянган төгрөгийн зөрүүтэй /дутуу/ бүртгэгдсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1-т “үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй

бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх”, 14 дүгээр зүйлийн 1-т “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлэн 5.1.4-т “үнэн зөв байх”, Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 10-р тогтоолын 7 дахь заалт” зэргийг хэрэгжүүлж ажиллаагүй ба “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нүүрсний 41 748.8 мянган төгрөгийн худалдан авалтын баримтыг “Могойн гол” ХК шивээгүй санхүүгийн тайланд анхан шатны баримтгүй гүйлгээ тусгагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”; Нэмэгдсэн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.17.2-т “худалдан авалт цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдсэн байх”, 15.17.3-д “татварын албаны шаардлагад нийцсэн цахим төлбөрийн баримт авсан байх” гэсэн заалтуудыг зөрчсөн ба “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Fas.audit.mn сайтад мэдээлж баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Завсрын аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Залруулга	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Компанийн ТУЗ-ын гишүүдийн цалин, урамшуулал тогтоосон болон олгох шийдвэргүй бизнес төлөвлөгөөнд тусган батлуулж, татвар, нийгмийн даатгалын шимтгэл тооцож суутгаагүй 1 200.0 мянган төгрөгийн цалин, урамшуулал олгосон байна.	1	1,200.0					1	1,200.0		
Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөөг нүүрсний худалдан авалтын хөнгөлөлт тооцоогүй үнээр төлөвлөж зардал өсгөж 60 754.7 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөж батлуулсан байна	1	60,754.7					1	60,754.7		
Шатахууны тооцооллыг шалгахад шатахууны тайлан байхгүй, тооцоо бодсон тооцоолол болон зарлагын анхан шатны баримтгүй 5 675.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна	1	5,675.9							1	5,675.9
Биет бус хөрөнгийн дансанд 19м.кв, 209м.кв нийт 228 м.кв талбайтай 2 хэсэг 456.0 мянган төгрөгийн өртөгтэй газар бүртгэлгүй байна. Улсын цахим бүртгэлийн нэгдсэн системд уг 2 газар эзэмших эрх Галт дулаан ХХК-ийн нэр дээр байгаа болно.	1	456.0					1	456.0		
Нийгмийн даатгалын тайланд 5 сард 3 ажилтаны 1 168.2 мянган төгрөгийн цалин дутуу, 9 сард 7 ажилтаны 1 169.8 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан.	1	2,338.1							1	2,338.1
Шилэн дансанд 2 мэдээ хугацаа хоцроож хөрөнгө орлогод авсан тушаал болон тооллого комиссын тушаал, 3 239.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актласан тушаал зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна.	1	3,239.6					1	3,239.6		
Хөрөнгийн бүртгэл хангалтгүй эд хариуцагчийн карт байхгүй, хагас жилийн тооллого хийгдээгүй, биетээр байгаа хөрөнгө санхүүгийн тайлангийн хөрөнгийн бүртгэлтэй тохирохгүй, биетээр ашиглагдаж байгаа хөрөнгө бүртгэлд байхгүй, ашиглагдахгүй хөрөнгийг актлах шийдвэр гаргуулаагүй зэрэг зөрчилтэй байна.	1	-					1	-		
Хагас жилээр 74 060.8 мянган төгрөгийн авлага, 68 324.2 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	142,385.1					1	142,385.1		
Татварын тайлангийн орлого, орлого үр дүнгийн тайлангийн орлого 68 569.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна.	1	68,569.5							1	68,569.5
Нийт дүн	9	284,618.9					3	142,841.1	3	76,583.5

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татварын тайлангийн орлого, орлого үр дүнгийн тайлангийн орлого 26 461.9 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна.	1	37,961.7			1	37,961.7	1	37,961.7				
Дүн	1	37,961.7			1	37,961.7	1	37,961.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 133 216.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй 19 нэр төрлийн 20 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	1	-					1	-				
Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй газар эзэмших эрхийн хэмжээ цахим системээс 228м.кв буюу 456.0 мянган төгрөгийн зөрүүтэй /дутуу/ бүртгэгдсэн байна.	1	456.0					1	456.0				
Нүүрсний 41 748.8 мянган төгрөгийн худалдан авалтын баримтыг "Могойн гол" ХК шивээгүй санхүүгийн тайланд анхан шатны баримтгүй гүйлгээ тусгагдсан байна.	1	41,748.8					1	41,748.8				

Тайлангийн хугацааны эцэст 30 959.0 мянган төгрөгийн авлага, 13 002.3 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	43,961.3			1	43,961.3						
Шатахууны тооцооллыг шалгахад сарын бүрийн эцэст шатахууны тооцоог бодсон 6 сард 147.5 литр 431.7 мянган төгрөгийн түлш илүү зарцуулснаар тооцсон байна.	1	431.7	1	431.7								
Компанийн ТУЗ-өөс 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 60 754.7 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан. Тайлант онд орлогын төлөвлөгөөг 69 307 мянган төгрөгөөр тасалдуулан, цахилгааны зардал, төлбөр хураамж, сэлбэг хэрэгсэл, тэтгэмж урамшууллын зардлууд батлагдсан төлөвлөгөөнөөс хэтэрсэн байна	1	0			1	0						
Дүн	2	86,597.8	1	431,7	2	43,961.3	3	42,204.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 3 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллогын комиссын тушаал, худалдан авах ажиллагааны тайлан, нэмэгдсэн хасагдсан хөрөнгийн шийдвэр зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-